ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 01 сарын 09 өдөр Дугаар А/02 Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1 дэх заалт, 8.4 дэх хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэг, Засгийн газрын 2022 оны 470 дугаар тогтоолоор батлагдсан "Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах нийтлэг журам"-ын 2.1, Эдийн засаг, хөгжлийн сайдын 2022 оны А/167 дугаар тушаалаар батлагдсан "Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал"-ын 2.1, 3.1-т заасныг үндэслэн ТУШААХ нь:

1.Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний төсөлд тусгах саналыг хууль тогтоомжийн хүрээнд судлан боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

Ахлагч:	Н.Ганболд	-	Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга;
Гишүүд:	В.Дарханбаатар	-	Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн Удирдлага, төлөөллийн албаны ахлах мэргэжилтэн (Албаны дарга);
	Д.Тунгалагтуул	-	Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн;
	Э.Ганчимэг	-	Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн;
	Г.Туул	-	Захиргаа, удирдлагын хэлтсийн Дотоод ажил хариуцсан ахлах мэргэжилтэн;
	Ц.Гантуяа	-	Ерөнхий нягтлан бодогч;
	Д.Цэрэнлхам	-	Захиргаа, удирдлагын хэлтсийн Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын мэргэжилтэн;
	Д.Дариймаа	-	Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн;
	Б.Сүнжидмаа	-	Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн мэргэжилтэн;

13201 3494

	Б.Янжинлхам	-	Хууль, эрх зүйн хэлтсийн хуулийн мэргэжилтэн;
Нарийн бичиг:	Х.Энхчимэг	-	Захиргаа, удирдлагын хэлтсийн Тогтоол шийдвэрийн биелэлт хариуцсан ахлах мэргэжилтэн.

2.Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний төсөлд тусгах саналыг хууль тогтоомжийн дагуу нөхцөл байдлын дүн шинжилгээнд тулгуурлан боловсруулж, 2023 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр танилцуулах, холбогдох байгууллагад хуулийн хугацаанд хүргүүлэх арга хэмжээ авч ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга Н.Ганболдод үүрэг болгосугай.

3.Төлөвлөгөөг боловсруулахад шаардлагатай судалгаа, мэдээллээр хангаж, санал, үр дүнг төлөвлөхөд хариуцсан чиг үүргийн хүрээнд ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэх, уялдаа холбоог хангаж ажиллахыг хэлтэс, албаны дарга нарт даалгасугай.

ДАРГА Б.ЦЭНГЭЛ